

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2013 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА №1

№	Зорилт, арга хэмжээний дугаар	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	2013 онд хүрэх түвшин, үр дүн	Зорилт, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр /сая төгрөг/		Хариуцан хэрэгжүүлэгч /яам, газар, агентлаг, аймаг, нийслэл/	Хэрэгжилтийн байдал		Тайлбар буюу /Шалтгаан/	
					Төлөвлөсөн	Гүйцэтгэл		ТЭЗ-ийн тайлагнасан /хэрэгжилтийн хувь/	ҮАГ-аас аудитлагдсан /хэрэгжилтийн хувь/		
А		1	2	3	4	5	6		7	8	
НЭГ. ӨСӨЛТИЙН ҮР ШИМИЙГ НИЙГМИЙН БҮХ БҮЛГҮҮДЭД ХҮРГЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО											
Зорилт-1. Эдийн засгийн өсөлтийг оролцоотой, хүртээмжтэй болгоход чиглэгдсэн макро эдийн засгийн тэнцвэрт бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангана.											
1	1.2	Бодит эдийн засаг, мөнгө, санхүүгийн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, инфляцийн түвшинг хэт өсгөхгүй байх;	Бэлтгэх нөөцийн махны хэмжээ	12.0 мянган тонн			ҮХАА Г, Зуунмод мах боловсруулах үйлдвэр	2013 онд Зуунмод мах боловсруулах үйлдвэр 22.5 тн мах нөөцөлж бэлтгэн нөөцийн махны нэрийн дэлгүүрээр 21.2 тн мах, 1.2 тн дайвар бүтээгдэхүүн борлуулсан. Бууз, банш, таташ зэрэг 3 нэр төрлийн бүтээгдэхүүн 7.2 тн-ыг үйлдвэрлэн савлаж дотоодын хэрэгцээнд нийлүүлэн нийт 82843.1 мянган төгрөгийн борлуулалт хийсэн. Үүнээс аймгийн төвийн сургууль, цэцэрлэг зэрэг нийгмийн салбарын хэрэгцээт махыг гэрээний дагуу бэлтгэн 11.4 тн-ыг нийлүүлсэн.	100%	100%	
2	1.3	Төсвийн шинэтгэлийг үргэлжүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсвийн зохистой харьцааг хадгалах;	“Сум хөгжүүлэх сан”-гийн үйл ажиллагааны хэрэгжилт	100 хувь	4,9 тэрбум	4.9 тэрбум	Хөдөлмөрийн хэлтэс	Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 11-ний А/38 дугаар тушаалаар манай аймагт 2013 онд сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрт 1,7 тэрбум төгрөг төсөвлөгдөн хуваарийн дагуу сум бүрт санхүүжилтийг хуваарилсан. Сум хөгжүүлэх сангийн 2012-2013 оны эх үүсвэрийг Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах,	100%	100%	

								хяналт тавих журам”-ын дагуу сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагт хөгжүүлэх, суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн 27 сумын 800 гаруй иргэн, аж ахуй нэгжид 4,9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож 593 нийгмийн даатгалын шимтгэлээр баталгаажуулсан шинэ ажлын байрыг нэмэгдүүлэн 235 ажлын байр хадгалагдаж, 60 гаруй жижиг үйлдвэр цех шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн.			
Зорилт-3. Бодит салбарын хөгжлийг эрчимжүүлэх, металл боловсруулах болон өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлнэ.											
3	3.4	Барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулах, барилгын материалын лабораторийн сүлжээг бэхжүүлэх;	Шинээр байгуулах үйлдвэрийн тоо	12		300.0 сая	ҮХАА Я, ХБХ	“Монгол алт” ХХК нь Сэргэлэн сумын нутагт хоногт 900 м3 жилд 270 мянган м3 хийц бетон үйлдвэрлэх хийц бетоны үйлдвэрийг шинээр барьж байна. Сэндвичин хавтангийн цех байгуулах төслийг “Өгөөмөр уул” ХХК боловсруулсныг ЖДҮ-ийг дэмжих сангаас дэмжсэн. Хайрга дайрганы үйлдвэр төслийг “Тусгал төв” ХХК боловсруулан элс, хайрга олборлох газрын зөвшөөрлөө авч нөөц тогтоох ажил хийсэн. Аймгийн нэгдсэн лаборатори байгуулах ажилд 300,0 сая төгрөг тусгагдаж барилгын ажлыг эхлүүлсэн. Одоогоор 2 давхар хүртэл өрлөг хийж, дулааны шугам сүлжээнд холбох ажлыг хийсэн. 2014 онд үлдэгдэл 306,9 сая төгрөгийн ажил хийгдэж 6 сард ашиглалтанд орох юм. 2013 онд хийгдэх ажлууд бүрэн хийгдсэн болно.	50 %	50%	Барилгын материалын үйлдвэр байгуулах төслүүд бэлэн болсон боловч төсөв нь шийдэгдээгүй. 2014 оны үндсэн чиглэлд шилжиж орсон.
Зорилт-5. Хөдөө аж ахуйн салбарыг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэл, үр ашгийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэн хүн амын эрэлт хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах чиглэл баримтална.											

4	5.1	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;	Шинээр байгуулах болон сэргээн засварлах түүхий эдийн агуулахын тоо	Аймаг бүрт 1			ҮХАА Я, ҮХАА Г	Баянчандмань, Бүрэн, Баяндэлгэр, Заамар сумын 120 гаруй малчин өрхийг нэгтгэсэн 4 хоршоо шинээр байгуулагдан гэрчилгээ авсан. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн чиглэлийн 78 хоршоо үйл ажиллагаа явуулж Баянчандмань, Борнуур, Баянжаргалан, Өндөрширээт, Эрдэнэ, Эрдэнэсант сумдад нийт 6 жишиг хоршоо үйл ажиллагаа явуулж байна. ҮХААЯ-наас 2013 онд эдгээр 6 хоршооны чадавхийг бэхжүүлэхэд тус бүр 9.0 сая, нийт 54 сая төгрөгийн буцалтгүй зээлийн дэмжлэг үзүүлсэн. Мөн аймгийн ЖДҮ-ийг дэмжих сангаас төсөл шалгаруулан Борнуур сумын “Бортолгой” жишиг хоршоонд ногоон тэжээл тариалах чиглэлээр 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож 20 га-д ногоон тэжээл тариалсан, мөн Зуунмод сумын “Түмэн мэгж” хоршоо гахайн аж ахуйн чиглэлээр 30.0 сая, Эрдэнэ сумын “Батцагаан эсгий” хоршоо 15,0 сая төгрөгийн зээлийг тус тус авч үйл ажиллагаа явуулж байна.	70 %	50%	Шинээр болон сэргээн засварлаж түүхий эдийн агуулах барих ажил төсөв санхүүгийн асуудал шийдээгүйг ээс баригдааг. ХАА-н биржийн арилжаанд оролцох эрхтэй брокерын кампани нэг банья.
			ХАА-н биржийн үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэн байна					“Хоршоо, бирж, брокерийн тухай ойлголт”, хөдөө аж ахуйн бараа түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэлт, урамшуулалын талаар малчид, иргэдэд 3-6 цагийн сургалт, ярилцлагыг 27 сумын төвд зохион байгуулж явууллаа. Энэ сургалтыг ҮХААЯам, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, МУСҮТөв, МЭҮГазар, ХААИС-ийн Биологийн нөөцийн менежментийн сургуулиас хүмүүс ирж сургалт явуулан зөвлөгөө заавар өглөө. Сургалтанд 27 сумаас нийт 1043 малчид, иргэд хамрагдлаа. 2013 оны 4 сараас Эрдэнэсант сумын Г.Эрдэнэсант захиралтай Сантланс ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч брокерын компаниар бүртгүүлэн биржийн арилжаанд байнгын гишүүнээр оролцож байна.			

5	5.2	Малын тэжээлийн үйлдвэр, цехийг бүсчлэн байгуулж, хадлан тэжээл бэлтгэх, таримал тэжээлийн үр үржүүлэг, тариалалтыг дэмжих;	Зээлээр байгуулах малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо	25			ҮХАА Я, ҮХАА Г	Аймгийн хэмжээнд Аргалант, Архуст, Баян-Өнжүүл, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Жаргалант, Заамар, Лүн Угтаал, Цээл, Эрдэнэсант зэрэг 13 суманд 14 тэжээлийн үйлдвэр бага оврын цехүүд ажиллаж байна. Тогтвортой амьжиргаа 2 төслийн санхүүжилтээр 2013 онд Баянчандмань суманд 11,6 сая төгрөг, Борнуур суманд 8,1 сая төгрөгөөр тэжээлийн бага оврын цех байгуулсан. Энэ онд аймгийн хэмжээнд 10,0 мянган тн малын тэжээл үйлдвэрлэж орон нутгийнхаа хэрэгцээг хангаад байна.	100%	100%	
6	5.3	Фермерийн аж ахуй эрхлэх, өндөр ашиг шимтэй малыг үржлийн чиглэлээр өсгөн бойжуулахыг дэмжих;	Шинээр байгуулагдах фермерийн тоо	10			ҮХАА Я, ҮХАА Г	2013 онд Архуст суманд Франц улсаас мах-сүүний чиглэлийн шар тарлан /Монбиллиард/ үүлдрийн 5 бух, 150 гунж оруулж ирэн Баттөгс захиралтай “Хишигтэн нүүдэлчин” ХХК-д хариуцуулан өгч, Ноёншанд гэдэг газар төлийн байр болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлтгэл ажлууд хийгдлээ. Мөн Баянчандмань сумын “Монмилк” ХХК-нд Францаас 24 сарын настай 50 үнээ оруулж ирэн фермерийн аж ахуй болон түүнд хамрагдах малын тоо толгой нэмэгдэж байна. Ингэснээр аймгийн хэмжээнд сүү, махны чиглэлийн ферм 246, түүнд хамрагдах малын тоо урьд оноос 10 орчим хувиар өсч 12 мянга гаруй толгой үхэр хамрагдаж байна. Махны чиглэлийн үхэр, хонь үржүүлэхээр Архуст сумын “Хустайнтүмэн” хоршоо 15.0, мөн сумын “Гантутур” ХХК 10.0, Алтанбулаг сумын “Арвижихбулаг” ХХК 10.0, Баянцогт сумын “Хангинах” хоршоо 20.0, сүүний үхрийн аж ахуйн чиглэлээр Баянчандмань сумын “Итгэлтдайчин” ХХК 20.0, Борнуур сумын “Урьд баянтөгөл” ХХК 20.0, Зуунмод сумын “Уваауул” ХХК 15.0, Эрдэнэ сумын “Өгөөмөр баянзүрх” ХХК 20.0, Угтаалцайдам сумын “Сонинхангайн андууд ” БГБХНөхөрлөл 10.0, зөгийн аж ахуйн чиглэлээр Батсүмбэр сумын иргэн Ц.Булган 5.0, гахайн аж ахуйн чиглэлээр Баянцогт сумын “Зургаанхошуу” ХХК 40.0, Эрдэнэ сумын “Цантөргөө” ХХК 10, нийт 12	100%	100%	

								аж ахуйн нэгж иргэд 195.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олгон үйл ажиллагааг нь дэмжлээ.			
7	5.5	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, зооноз халдварт зарим өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх;	Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамрагдах малын тоо	15.1 сая толгой			ҮХАА Я, ҮХАА Г	Халдварт өвчнөөс сэргийлэх 18 нэрийн вакцинжуулалтанд давхардсан тоогоор 2102,9 мянган мал хамруулсан. Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсөнд Орон нутгийн төсвөөс 350,0 сая төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээний 84 нэгжид сумдын төрийн сангаар дамжуулан бүрэн олгосон.	100%	100%	
			Зооноз халдварт зарим өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо	14.3 сая толгой				Мал, амьтнаас хүнд дамжин халдварлах зооноз бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 27 сумын 1071,0 мянган төл малыг хамруулсан. Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсөнд 163,6 сая төгрөгийг Улсын төсвөөс олгосон.			
8	5.7	Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд дэвшилтэт арга, технологи ашиглах;	Шинээр тогтоох уст цэг болон барих худгийн тоо	500 уст цэг 900 худаг	322,0 сая	322,0 сая	ҮХАА Я, ҮХАА Г, БОГ	2013 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн усан хангамжийг сайжруулахаар нийт инженерийн хийцтэй 23 худаг гаргахаас 22 худгийг нь бүрэн гаргаж Улсын комисс хүлээн аваад байна. Тус ажилд Улсын төсвөөс 322,0 сая төгрөг зарцуулсан. Дээрх ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулахад нийт 3 багцад нээлттэй тендер зарлаж 1-р багцад Монтегео ХХК, 2, 3-р дугаар багцуудад Эрдэнэдрилинг ХХК компани шалгарч ажлаа чанартай гүйцэтгэсэн. Үүний үр дүнд аймгийн нийт бэлчээр усжуулалт 60 хувьд хүрлээ. Энэ онд аймгийн хэмжээнд бэлчээрийн хөнөөлт мэрэгчтэй 7 суманд / Баянжаргалан, Баянцагаан, Архуст, Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Цээл, Борнуур/ 45,0 мянган га-д энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Үүний үр дүнд	100%	100%	

								аймгийн хөнөөлт мэргэчийн тархалт 80-84 хувиар буурсан. Аймгийн хэмжээнд нийт 100 ширхэг шувууны үүрийг сумдад нийлүүлж биологийн тэмцэх аргыг давхар хэрэгжүүлсэн.. Улсын төсвөөс нийт 70,6 сая төгрөг зарцуулсан байна.			
9	5.9	Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэлийг үргэлжлүүлэн, таримал ургамлын элит үр үржүүлэг, шинэ сортыг бий болгох, нутагшуулах;	Хүчин чадлын өсөлт, /хоногоор/ - Тариалалт - Уринш - Ургац хураалт	14-21 хоног 7-10 хоног 25-30 хоног			ҮХАА Я, ҮХАА Г	Энэ онд 6 сумын 14 аж ахуйн нэгж, 18 иргэн үр тарианы комбайн 6, төмсний комбайн 2, өөрөө явагч зүтгэх хүчний техник 7, төмс ухагч 18, чиргүүл дүүжин машин 22 ширхэгийг шинээр авч, техник шинэчлэл хийсэн. - Энэ хаврын тариалалтанд өөрөө явагч 258 трактор, үрлэгч 340 агрегат, 236 сийрүүлэгч ажиллаж хаврын тариалалтыг 21 хоногт багтаан дуусгасан. -Энэ жилийн уринш боловсруулалтанд өөрөө явагч 258 трактор, 236 сийрүүлэгч ажиллануриншийн нэг удаагийн боловсруулалтыг ажлын 8 хоногт дуусгасан бөгөөд уриншийн зээлэнд 13 сумын 170 ажахуйннэгж,160 иргэний 81677 га-д уринш боловсруулах захиалгыг авч нэгтгэн ҮХААЯ-нд хүргүүлж шийдвэр гаргуулснаар зээлэнд хамрагдсан ААН, иргэд 50 хувийн урьдчилгаа төлж, ТЭДС-тай гэрээ байгуулан шатахуунаа авсан. - Энэ жилийн ургац хураалтын ажилд үр тарианы комбайн 235, төмсний комбайн 36, төмс ухагч 112, төмс сортлогч 10, будаа цэвэрлэгч 71, сортлогч 15, ачигч 46, механикжсан үтрэм 19 ажиллан, ургац хураалтыг ажлын 30 хоногт дуусгасан.	100%	100%	
10	5.11	Хүлэмж, үрсэлгээ бойжуулах төрөлжсөн аж ахуй болон хүнсний ногооны механикжсан зоорь барих;	Шинээр барих нийлэг хальсан хүлэмжийн багтаамж	20.0 мянган м2			ҮХАА Я, ҮХАА Г	Зуунмод сумын 1 аж ахуйн нэгжид гүзээлзгэнэ тарих зориулалтаар 1000 м ² талбай бүхий зуны нийлэг хальсан хүлэмжийг суулгацын хамт олгож, дэмжлэг үзүүлсэн. ҮХААЯ-наас зарлагдсан "Өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах" төслийн шалгаруулалтанд Зуунмод сумын 1 аж ахуйн нэгж	100%	100%	

			Шинээр барих өвлийн хүлэмжийн багтаамж	30.0 мянган м2			ҮХАА Я ҮХАА Г	шалгаран 2000 мкв хүлэмжийг энэ онд ашиглалтанд оруулан тарвас, гүзээлзгэнэ тариалсан ҮХААЯ-наас зарлагдсан ”Өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах” төслийн шалгаруулалтанд Зуунмод сумын 1 аж ахуйн нэгж2012 онд шалгаран 2000 мкв хүлэмжийг энэ онд ашиглалтанд оруулан тарвас, гүзээлзгэнэ тариалсан. Хүлэмжийн талбайн хэмжээ 71609 м ² -д хүрч хүлэмжийн талбайн хэмжээ өмнөх жилээс 3000 мкв-аар нэмэгдсэн. Энэ жил 13 төрлийн хүнсний ногоог ил талбайн 867 га-д, тавцангийн аргаар гүзээлзгэнийг хүлэмжийн 1000 мкв талбайд, 9-н төрлийн нарийн болон жимст ногоог хамгаалагдсан хөрсний 5.8 га-д тус тус тарьсан. Хүлэмжийн 57871 мкв талбайгаас 222.7 тн ургац хураан авсан. Монгол төмс” хөтөлбөртэй хамтарч төмсний хадгалалтын хугацааг уртасгах зоорийн багтаамж нэмэгдүүлэх зорилгоор төмс хадгалах зоорь барихад эргэн төлөгдөхгүй нөхцлөөр Жаргалант сумын 25 ногоочин, Борнуур сумын 17 ногоочдод нийт 21 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 328 тн багтаамжтай зоорь шинээр баригдсан. ҮХААЯ-наас Баянчандмань сумын иргэнд 200 тн зоорь барихад нь дэмжлэг үзүүлсэн. Агро-Альфа ХХК 2000 тн багтаамжтай механикжсан зоорь шинээр барьж ашиглалтанд оруулсан. Зоорийн хэмжээ 38299 тн-ы багтаамжтай 2403 зоорийг ашиглаж байна. Зоорийн багтаамжийн хэмжээ өмнөх оноос 2528 тн-оор, механикжсан зоорийн багтаамжийн хэмжээ 2000 тн-оор тус тус нэмэгдсэн.			
			Шинээр барих төмс, хүнсний ногооны зоорийн багтаамж	20.0 мянган тонн			ҮХАА Я ҮХАА Г				
Зорилт-6. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн техник, технологийг нутагшуулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн кластерүүдийг хөгжүүлнэ.											
11	6.3	Бүсийн тулгуур төв, зарим аймаг, хотод аж үйлдвэрийн парк, жижиг, дунд үйлдвэрийн кластер байгуулах судалгаа	Шинээр боловсруулах ТЭЗҮ-ийн тоо	3-аас доошгүй			ЭСХЯ, ХБХ	“Могол ноос” компани нь Баянцогт суман дахь ноос угаах үйлдвэрээ Зуунмод хотод хоногт 2-3 тонн ноос, ноолууран утас үйлдвэрлэх хүчин чадал бүхий ээрмэлийн үйлдвэрийг ашиглалтанд орууллаа. Ээрсэн утсаа БНСУ-д экспортлож даавуу үйлдвэрлэн дотоодпын	100%	100%	

		хийх;						хэрэгцээнд нийлүүлж байна. Ирэх оноос даавууны үйлдвэрийг ашиглалтад оруулан эхний ээлжинд сурагчийн болон төрийн албан хаагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэж, цаашид Монгол улсын ноос ноолууран даавууны хэрэгцээг хангахаар төлөвлөж байна.			
Зорилт-7. Хүн амын нутагшил, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, сууринг хөгжүүлж, хүн амын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.											
12	7.2	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд 100 мянган айлын орон сууцыг барих ажлыг үргэлжлүүлэх;	Орон сууцны зээлд хамрагдах өрхийн тоо	1000		6210.3 сая	БХБЯ ХБХ	Аймгийн хэмжээнд ХАС, ХААН, Төрийн банк үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр банкнууд орон сууцны зориулалттай зээлийг олгож байна. 2013 онд: -ХАС банк 39 иргэнд 815,0 сая төгрөгийн зээл олгосон ба үүнээс 8 %-ийн хүүтэй зээлийг 36 иргэнд 705,3 сая төгрөгийн зээлийг олгосон байна. -ХААН банк 183 иргэнд 5296,0 сая төгрөгийн зээл олгосон ба үүнээс 8 %-ийн хүүтэй зээлийг 134 иргэнд 4984,0 сая төгрөгийн зээлийг олгосон байна. -Төрийн банк 16 иргэнд 99,3 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Аймгийн хэмжээнд нийт 238 иргэнд 6210,3 сая төгрөгийн орон сууцны зээлийг олгосон байна.	100%	100%	
Зорилт-8. Эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжсэн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ.											
13	8.16	Орон нутгийн дулаан хангамжийг сайжруулах;	Шинээр дулааны станц, дулааны шугам барих аймгийн тоо	3	3000.0 сая	3000.0 сая	ЭХЯ ХБХ	Зуунмод хотын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 1000 айлын орон сууцны хороолол төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Дэд бүтцийн ажил буюу шугам сүлжээ, цэвэр бохир усны шугамын ажилд шаардагдах 3,0 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ хийсэн. Дээрхи ажлуудыг гүйцэтгэхээр “Нишин илч” “Набсан” ХХК-нуудын түншлэл гэрээ байгуулаад байна.	100%	100%	
			Шинээр боловсруулах ТЭЗҮ-ийн тоо	1							
14	8.19	Сайншандын салхин паркийг барьж, төвийн эрчим хүчтэй холбох;	Шинээр байгуулах салхин паркийн хүчин	52 МВт			ЭХЯ	Сэргэлэн сумын Салхит ууланд 50 МВт хүчин чадал бүхий салхин парк 2013 оны 7-р сард ашиглалтанд орсон	100%	100%	

			чадал								
Зорилт-9. Эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангахад чиглэсэн мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэд бүтцийг бий болгоно.											
15	9.1	Монгол Улсад өндөр хурдны, найдвартай, үндэсний хэмжээний харилцаа холбооны сүлжээг байгуулах;	Интернэт протокол д суурилсан түгээх сүлжээ болон шилэн кабелийн сүлжээнд холбогдох сумын тоо	55				Баянхангай, Баянцогт Угтаалцайдам, Цээл, Батсүмбэр Заамар, Лүн, Баянчандмань, Эрдэнэ, Архуст сумд шилэн кабелийн сүлжээнд холбогдсон ба бусад сумд нь үүрэн телефоны операторын модемоор интернетед холбогдох нөхцөл боломж бүрдсэн	100%	100%	
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
Зорилт-10. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгаж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулан, биологийн нэн ховор төрөл зүйлийг хамгаална.											
16	10.9	Газрын доорхи усны эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж, нөөцийг тогтоох;	Хөв цөөрөм байгуулах судалгаа, зураг төслийн тоо	3 судалгаа 5 зураг төсөл			ҮХАА Я, БОГ, ҮХАА Г	Цас борооны ус хуримтлуулах хөвийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар буюу төсвийн тодотголоор тус ажлыг энэ онд хийхгүйгээр шийдвэрлэсэн.	10%	0	Төсөв хөрөнгийн эх үүсвэр хүрэлцээгүй гээс Аймгийн ИТХ-аар хэлэлцээд хэрэгжүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн.

17	10.10	Усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулж, усны нөөцийн хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх;	Эхийг нь хамгаалах булаг шандны тоо	140			БОНХЯ, БОГ	2013 онд сумдад байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хуваарилсан хөрөнгөөр булаг шанд, рашааны эхийг хамгаалах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж 15 суманд 22 булаг, шандын эхийг хамгаалахад 31780.0 төгрөг байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахаар батлуулан тус ажлыг төсөл шалгаруулах журмаар зохион байгуулж Алтанбулаг сум 2-р багт Сэрүүний булаг, 3-р баг Өлзий булаг, 4-р баг Жаргалантын булаг, нийт 3 булгийн эхийг, Баянжаргалан Уушийн булагийн эхийг, Баян-Өнжүүл сум, 1-р багт Сүүжийн булаг, 2-р багт Их цээлийн булагийн эхийг, Бүрэн сум Сөдтий, Баянцагаан сум Элгэнэ, Нарангийн энгэр, Борнуур сум Далын рашааны эхийг 1500.0 төгрөгөөр, Дэлгэрхаан сум 2-р багийн нутагт “Дуутын булаг худаг” булгийг 1500.0 төгрөгөөр, Жаргалант сум Загдал 4-р багт Айрагийн булгийн эхийг, Заамар сум Төвийн багийн Бэлхийн голын эхийг 6800.0 Тосон багийн гичгэнэ булгийн эхийг 4000.0, Угтаал сум Өвөр асгатын эхний дээд булаг, Өвөр асгатын дунд булгийн эхийг, Эрдэнэ сум 2-р багийн нутагт Хөндлөн, Баруун цуурай, 1-р багийн нутагт Баяндавааны арын булгийн эхийг хамгаалж 1400 000 төгрөгөөр хамгаалсан тайланг ирүүлсэн.	100%	100%	
			Шинэчлэх болон шинээр байгуулах барилга, байгууламж, суурилуулах ажлын явц	100 хувь	2,9 сая улсын төсөв		БОНХЯ БОГ	Зуунмод сумын төвд ундны усны эх үүсвэрийн 2 цооногийг мэргэжлийн байгууллагаар өрөмдүүлж, тоноглов.			

ДӨРӨВ. ХҮНД ӨГӨӨЖТЭЙ НИЙГМИЙН БОДЛОГО

Зорилт-13. Бага, дунд боловсролын агуулга, стандарт, хөтөлбөр, сүрах бичиг, орчин, хүний нөөцийн чадавхийг олон улсын жишигт нийцүүлэн үе шаттайгаар хөгжүүлж,

өрсөлдөх чадвартай болгоно.											
18	13.4	Сургуулийн өмнөх насны болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн сурах орчинг сайжруулах;	Шинээр барих болон өргөтгөх сургууль, цэцэрлэг, дотуур байрны тоо	15 сургууль 40 цэцэрлэг 10 дотуур байр		3428,7 сая	БШУЯ ,	БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын сургуулийн 50 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр шинээр ашиглалтанд орж, Эрдэнэсант сумын сургуульд 150 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны барилгын гүйцэтгэл 80%-тай байна. Заамар суманд 4 бүлэг буюу 100 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн шинэ барилгыг “Алтан Дорнод Монгол” ХХК-ний хөрөнгө оруулалтаар, Баянхангай сумын 3-р багийн нутагт 25 хүүхдийн багийн цэцэрлэгийн барилгыг “Хустай байгалийн цогцолборт газар”-ын санхүүжүүлтээр, Жаргалант сумын Баянбулаг багийн цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулсан. 17 сумын 23 цэцэрлэг буюу 56.0% нь бага насны хүүхдэд ээлтэй, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын орчныг тохижууллаа. ЕБ-ын 13 сургууль гадаад хэлний кабинет, 12 сургууль химийн кабинет, 9 сургууль физикийн кабинет, 18 сургууль техник технологийн кабинет, 21 сургууль биеийн тамирын тоног төхөөрөмж шинэчлэх, 19 сургууль хөгжмийн кабинет, 22 сургууль бага ангийн <u>кабинетыг тохижуулсан.</u> Сургууль бүрт хүнсний бүтээгдэхүүн нөөцөлж, хадгалах эрүүл ахуйн шаардлагад нийцсэн өрөө, агуулахтай болох шаардлага тавьж ажилласнаар 21 сургууль буюу 67.7% нь эрүүл ахуйн шаардлагад нийцсэн агуулахтай болсон. ЕБ-ын 11 сургуулийн дотуур байр атмортой, 26 сургууль гадна бие засах газартай, 17 сургууль дотроо 00-той, 10 сургууль төвлөрсөн усан хангамжтай болсон. 30 цэцэрлэг хүнсний агуулах, зоориндоо их болон урсгал засвар хийн, 37 цэцэрлэг буюу 90.2% нь хоол хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хангамж сайжирсан. 17 сумын 19 цэцэрлэг стандартын шаардлага хангасан 45 гадаа бие заах газрын 100 суултуур, 69 дотор бие засах өрөөний 128 суултуур, 234 гар угаалтуурыг шинэчлэн	100%	100%	
			Эрүүл ахуй, ариун цэврийн норм, нормативын хангалт	20 хүртэл хувь			БШУЯ				

								засварлаж, 9 цэцэрлэг, 7 сургууль “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болзлыг хангасан.			
19	13.6	Ерөнхий боловсролын сургуульд эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангасан хяналтын тогтолцоо бүхий үдийн хоолны үйлчилгээг бий болгох;	Хөдөөгийн сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн шинэчлэлт	100 хувь		52.6 сая	БШУЯ	ЕБ-ын 31 сургуулийн бага ангийн 6433 суралцагч үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байна. Сургуулиуд “Үдийн цай”-г үдийн хоол болгон өргөжүүлэхтэй холбогдуулан 7 хоногт 2-5 удаа халуун хоолоор үйлчилж байна ЕБС-ийн 17 нь үдийн цайг ангид нь, 14 буюу 45.2% нь шаардлагад нийцсэн цайны газар болон дотуур байрны гал тогооны хоолны зааланд өгч байна. 2013 оны жилийн эцсийн байдлаар 24 сургууль буюу 85,7 хувь нь гал тогооны тоног төхөөрөмжөө шинэчилсэн.	100%	100%	
20	13.8	Мэдээлэл харилцаа холбооны технологийг сургалтад ашиглах суурь нөхцөлийг бүрдүүлэх;	Интернэтэд холбогдох сургуулийн тоо	120			БШУЯ	ЕБ-ын 31 сургууль сургалтын үйл ажиллагаанд нийт 666 компьютер ашиглаж, 20 хүүхдэд 1 компьютер ноогдож байна. 13 сургуульд мэдээлэл харилцаа холбооны технологийг сургалтад ашиглах боломж бүрдсэн. 17 сургууль нь суурин интернэтэд холбогдоогүй, 13 сургууль буюу 41.9% нь интернэтэд шууд холбогдсон.	100%	100%	
Зорилт-17. Эрүүл мэндийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, хүн амд ээлтэй, тэгш, хүртээмжтэй, чанартай эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэнэ.											
21	17.1	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг багасгахад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;	Интернэтэд суурилсан мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх аймгийн тоо	11		29.2 сая төгрөг	ЭМЯ	Нэгдсэн эмнэлгийн телемедицинээр зайн сургалтад 12 удаа нийт 144 эмч, мэргэжилтэн хамрагдаж, зайн уулзалт ярилцлага 9 удаа, зайн зөвлөгөө 2 удаа авч ажилласан. Мөн НЭ-ийн хүүхдийн тасагт НҮБ-ын Хүүхдийн сангийн төслөөр телемедицин зориулалттай иж бүрэн dell компьютер, notebook, зурагт, дүрс дамжуулагч болон бусад хэрэгслүүдийг суурилуулж, ЭХЭМҮТ-ийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасагтай шууд холбогдож эмчилгээ, оношилгооны хамтарсан зөвлөгөө хийж байна. 5 сумын ЭМТ шилэн кабелиар, 21 сумын ЭМТ, 2 өрхийн ЭМТ үүрэн холбооны утасны модем ашиглан интернэтэд холбогдож, тайлан, мэдээ, албан бичиг, статистик мэдээллийн базаа шуурхай дамжуулан ажиллаж байна.	70%	50%	
			Шинээр	Нийт			ЭМЯ	НЭМ-ийн тусламж үйлчилгээний бүтэц, зохион			Эрүүл

			байгуулах нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо	аймаг, дүүргийн 50-аас доошгүй хувь				байгуулалтын өнөөгийн байдал, хүний нөөцийн байршил хангамж, сургалтын тоног төхөөрөмжийн хангалтын талаар асуумж судалгаа авч, “Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай” аймгийн Засаг даргын захирамжийн төслийг бэлтгэн, шаардлагатай хөрөнгө болон цалинг 2014 оны төсөвт суулгахаар ЭМЯ, НЭМҮТ-д хүргүүлсэн боловч батлагдаагүй.			Мэндийн Яамнаас төсөв батлагдаж ирээгүйгээс хэрэгжээгүй байна.
22	17.2	Нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн чанартай, үр дүнтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх;	Гэмтлийн яаралтай тусламжийн тасаг нэмж байгуулах сум дундын болон аймгийн нэгдсэн эмнэлэг	25-аас доошгүй хувь		25,8сая	ЭМЯ	Нэгдсэн эмнэлгийн Сэхээн эрчимт эмчилгээний Хүлээн авах яаралтай тусламжийн нэгжид "Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр III"-ийн санхүүжилтээр өвчтний ор, ЭМЯ-ний хөрөнгө оруулалтаар Хүчил төрөгч өтгөрүүлэгч, ЭКГ-ийн аппарат авсан. Баянчандмань, Борнуур, Лүн, Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвд тус бүр 12 нэр төрлийн нийт 11.9 сая төгрөгийн үнэ бүхий осол, гэмтэл, яаралтай тусламжийн иж бүрдэл ЭМЯ-наас олгож, яаралтай тусламжийн хэсгийг байгуулан, яаралтай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж байна.	100%	100%	
			Автомашин парк шинэчлэлт	25 хувь		6 машин 136,79 сая 8 мотоцикл-8,48 сая нийт 145,27 сая	ЭМЯ	Өвсний үндэс хөтөлбөр, “Хүчитбаатар” сан, АСЕК ТББ–аас НЭ-т 2ш, Алтанбулаг сумын ЭМТ-д 1ш, ЭМЯ-аас НЭ, Борнуур, Цээл сумын ЭМТ-д түргэн тусламжийн тоноглогдсон автомашин нийлүүлж, парк шинэчлэл хийлээ. "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд 8.480.000 төгрөгөөр 8 мотоцикль багийн эмч нарт өгсөн.			
			Цахим сүлжээнд холбогдох сумдын эзлэх хувь	20 хүртэл			ЭМЯ	МУЗГ-аас хэрэгжүүлж буй төслөөр Монголын цахилгаан холбоо, технологийн газраас 5 сумыг шилэн кабельд холбосноор төрийн байгууллагууд өндөр хурдны интернэтэд шууд холбогддог болсон. 21 сумын ЭМТ, 2 өрхийн ЭМТ үүрэн холбооны утасны модем ашиглан интернэтэд холбогдож байна.			

ТАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Зорилт 20.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэн, төр хувийн хэвшлийн түншлэлийг

сайжруулна.											
23	20.3	МХЕГ-ын төв байр, аймаг, нийслэлийн дүүргүүд, хилийн боомт дахь мэргэжлийн хяналтын байгууллагыг ажлын болон лабораторийн байраар хангах;	Аймаг, дүүргийн МХА-ны шинэ барилгын тоо	5 аймаг, дүүрэг	609.9 сая	300.0 сая	МХЕГ	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр нийт 609.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий лабораторийн барилга шинээр барихаас 2013 онд 300.0 сая төгрөг батлагдаж барилгын гүйцэтгэл 45%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. 2014 онд 309.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Одоогоор барилгын ажил эхлээгүй байна.	100%	100%	
Зорилт-21. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, архив, төрийн албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлнэ.											
24	21.3	Орон нутгийн алслагдсан сумдад цагдаагийн кобан барих ажлыг үргэлжүүлэх;	Шинээр барих кобаны тоо	38	144.0 сая	144.0 сая	ХЗЯам, Төв аймаг	2013 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хууль зүйн сайдын багцаас Сүмбэр, Баянхангай суманд кабоны байр баригдаж ашиглалтанд орсон.	100%	100%	
НИЙТ									91.66	89.58	

Судалгаа гаргасан

Аудитор

_____ Д.Пүрэвсүрэн / 2014,03,04/

Хянасан.

Аудитын менежер

_____ О. Амаржаргал /2014,03,04/

Зөвшөөрсөн.

ДАХШҮ-ний албаны дарга

_____ Д. СаранЭрдэнэ /2014,03,04/